



“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 25/04

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.2, 60.4, 62 дугаар зүйлийн 62.1.7, 62.1.9, 62.1.14, 62.1.14, 62.1.15 дахь заалт, 64 дүгээр зүйлийн 64.2, 64.4, 65 дугаар зүйлийн 65.3, 65.4 дэх заалт, 67 дугаар зүйл, 71 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр 25-ны өдрийн 10:00 цагт “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн хурлын танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй:
 - 2.1 Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах,
 - ✓ Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах,
 - ✓ Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах,
 - ✓ Компанийн 2023 оны ногдол ашиг тараасан тухай тайлан болон 2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах,
 - ✓ Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны тайлан танилцуулах,
 - 2.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсөв батлах,
 - 2.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох,
3. “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдэл”-ийг 1 дүгээр хавсралтаар баталж, 2025 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн дотор багтаан Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэх, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар”-ыг 2 дугаар хавсралтаар баталж, 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллага, өөрийн цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сониноор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, мөн 2025 оны 04 дүгээр сарын 02-ний өдөр анх мэдээлсний дагуу хурлын зарыг дахин хүргэхээр тогтсугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2025 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн дотор багтаан хувьцаа эзэмшигчидтэй харилцаж буй брокер дилерийн компанид хүргүүлсүгэй.

5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөр тогтсугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн ердийн гишүүн О.Одбаярыг, нарийн бичгээр Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Цэцгээг тус тус томилсугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын даргаар “Монгол шуудан” ХК-ийн Мэдээллийн технологийн газрын ахлах инженер Ж.Даваасүрэн, Хүний нөөц, үйл ажиллагааны газрын эрх зүйч А.Энхзул болон “Ард Секюритиз ҮЦК” ХХК-ийн дэд захирал Г.Долгорсүрэн (зөвшилцсөнөөр) нарыг тус тус томилсугай.

8. Компанийн шуудангийн хаягаар болон брокер дилерийн компаниар дамжуулан урьдчилан санал авах сүүлчийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөр тогтоож, саналын хуудасны агуулга, загварыг 3, 4 дүгээр хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг 5 дугаар хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт болон тэдгээрийн бэлэн болгох эцсийн хугацааг 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар “Монгол шуудан” ХК-ийн Хүний нөөц, үйл ажиллагааны газрын захирал О.Отгонбаяр, гишүүдэд Хүний нөөц, үйл ажиллагааны газрын хүний нөөцийн мэргэжилтэн Б.Саруул, дотоод ажлын мэргэжилтэн Т.Хулан, Мэдээллийн технологийн газрын инженер Б.Дамдинсүрэн нарыг тус тус томилсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбогдон гарах зардлыг “Монгол шуудан” хувьцаат компаниас санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захиралд зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ



2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн
25.04 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ


Компанийн нэр:	"Монгол шуудан" ХК
Хаяг, утас:	Сүхбаатарын талбай-1 Чингэлтэй дүүргийн 1-р хороо Улаанбаатар 15160
Хурал хуралдах өдөр, цаг:	2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр 10:00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	"Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-ийн хурлын танхимд /Төв шуудангийн баруун хаалга, "Монгол шуудан" ХК-ийн 4 давхарт/
Хурлын төрөл:	Ээлжит хурал
Хурал зарлагч:	Төлөөлөн удирдах зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр
Олон нийтэд зарласан огноо:	2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр
Бүртгэлийн өдөр:	2025 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	2025 оны 03 дугаар сарын 23-ны өдөр
Хүргүүлсэн огноо:	2025 оны 03 дугаар сарын 23-ны өдөр
Хурлын даргын нэр:	О.Одбаяр
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	О.Отгонбаяр, Б.Саруул, Т.Хулан, Б.Дамдинсүрэн
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	"Монгол шуудан" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал - Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан - Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт - Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт - 2023 оны ногдол ашиг тараалтын тайлан болон 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хураарилах тухай ТУЗ-ийн шийдвэр - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны тайлан - Бусад хэлэлцэх асуудалтай холбоотой материалууд - ХЭ-чдийн ээлжит хурлаас гарах шийдвэрийн төслүүд
Баримт бичгийн хуудасны тоо: ширхэг
 хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

О.Отгонбаяр /О.Отгонбаяр/

2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

2025 оны 03 дугаар сарын 13-ний өдрийн
25/04 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

Компанийн оноосон нэр:

“Монгол шуудан” ХК, Сүхбаатарын талбай 1,
Энхтайвны өргөн чөлөө, ЧД 1 дүгээр хороо, Улаанбаатар 15160

Хурал хуралдуулах газар, өдөр, цаг:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 10:00 цагт “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн хурлын танхимд /Төв шуудангийн баруун хаалга, “Монгол шуудан” ХК-ийн 4 давхарт/

Хуралд оролцох эрхтэй ХЭ-чдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр:

2025 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах,
 - ✓ Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах,
 - ✓ Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах,
 - ✓ Компанийн 2023 оны ногдол ашиг тараасан тухай тайлан болон 2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах,
 - ✓ Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны тайлан танилцуулах,
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсөв батлах тухай,
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох тухай,

Холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:


1. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2025 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас (www.mse.mn/mn/company/541), компанийн цахим хуудас (www.mongolpost.mn)-аас электрон хэлбэрээр болон ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд өөрийн харилцаж буй брокер дилерийн компани болон компанийн төв байранд ирж авч болно.
2. Хувьцаа эзэмшигч та саналаа урьдчилан өгөх боломжтой бөгөөд өөрийн үйлчлүүлдэг Үнэт цаасны компаниар дамжуулж компанид ирүүлж болно. Мөн компанийн цахим хуудас (www.mongolpost.mn)-т байршуулсан саналын хуудсыг татан авч саналаа бөглөн дараах хаягаар битүүмжлэн ирүүлж болно. Саналын хуудсаар санал авах сүүлийн хугацаа 2025 оны 04 сарын 24-ний өдрийн 17:00 цаг байна.

Хаяг: Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисст
“Монгол шуудан” ХК, Сүхбаатарын талбай-1,
ЧД-ийн 1-р хороо, Улаанбаатар 15160

Холбоо барих:

Хурал зохион байгуулах комисс: О.Отгонбаяр, Б.Саруул, Т.Хулан, Утас: 70078906
otgonbayar@mongolpost.mn, saruul@mongolpost.mn, internal_work_specialist@mongolpost.mn

Хурлын ирцийн бүртгэл 2025 оны 04 сарын 25-ны өдрийн 09:30-10:00 цагийн хооронд явагдана.



“Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн
2025 оны 03 дугаар сарын 13-ний өдрийн
25/04 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС

/ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ-1, 2/

Компанийн оноосон нэр: **“Монгол шуудан” ХК**
Хурал хуралдах газар, өдөр: **“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн хурлын танхимд**
/Төв шуудангийн баруун хаалга, 4 давхарт/
2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр 10:00 цагт

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:	
Хувьцаа эзэмшигчийн утасны дугаар:	
Хувьцаа эзэмшигчдийн мэйл хаяг:	
Регистрийн дугаар:	
Эзэмшиж буй хувьцааны тоо:	

Санал хураах арга: **Энгийн**

№	Хэлэлцэх асуудал	Шийдвэр	Хувьцаа эзэмшигчийн санал		
			Зөвшөөрсөн	Татгалзсан	Түтгэлцсэн
1	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах	ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай			
2	ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг батлах тухай	Зардлын төсөв батлах тухай			

Заавар: Та өөрийн саналыг (“√” “болон “+”) тэмдгээр тэмдэглэнэ.

Хувьцаа эзэмшигч хувь хүний бөглөх хэсэг Овог нэр: Гарын үсэг:	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн бөглөх хэсэг Хуулийн этгээдийн нэр: Улсын бүртгэлийн дугаар:
Хувьцаа эзэмшигч хувь хүн болон хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн бөглөх хэсэг Нэр: Албан тушаал: Гарын үсэг:	
Саналын хуудсыг хүлээлгэн өгсөн огноо, цаг:	
Саналын хуудсыг хүлээн авсан этгээдийн нэр, гарын үсэг:	


Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): **Тийм** **Үгүй**

Комиссын дарга: /...../

Гишүүд: /...../

..... /...../

Саналын хуудсыг хүчингүйд тооцох үндэслэл:



“Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн
2025 оны 03 дугаар сарын 13-ний өдрийн
25.10.24 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС
/ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ-3/

Компанийн оноосон нэр: **“Монгол шуудан” ХК**

Хурал хуралдах газар, өдөр: **“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн хурлын танхимд**
/Төв шуудангийн баруун хаалга, 4 давхарт/
2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр 10:00 цагт

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:	
Хувьцаа эзэмшигчийн утасны дугаар:	
Хувьцаа эзэмшигчдийн мэйл хаяг:	
Регистрийн дугаар:	
Эзэмшиж буй хувьцааны тоо:	

Санал хураах арга: **Кумулятив**

Санал хураах кумулятив аргыг хэрэглэх тухай тайлбар:

- Кумулятив аргыг хэрэглэхэд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй энгийн нэг хувьцаа нь компанийн дүрмээр тогтоосон ТУЗ-ийн нийт гишүүдийн тоотой тэнцүү саналын эрхтэй байна.
- Хувьцаа эзэмшигч нь саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.

Жишээ нь: Хувьцаа эзэмшигч А нь 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Компанийн дүрмээр тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон. Хувьцаа эзэмшигч А-ийн эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй /100*9 гишүүн=900/ болно.

Хувилбар А: Хувьцаа эзэмшигч нь нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.

Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч нь нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно.

Хувьцаа эзэмшигч нь саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.

Саналын эрхтэй хувьцааны тоо-

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигч

№	Нэр дэвшигчийн овог, нэр	Саналын тоо
1		
2		
3		
4		
5		
6		

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бүс гишүүнд нэр дэвшигч

№	Нэр дэвшигчийн овог, нэр	Саналын тоо
1		
2		
3		
4		
5		
6		

Хувьцаа эзэмшигч хувь хүний бөглөх хэсэг Овог нэр: Гарын үсэг:	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн бөглөх хэсэг Хуулийн этгээдийн нэр: Улсын бүртгэлийн дугаар:
Хувьцаа эзэмшигч хувь хүн болон хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн бөглөх хэсэг Нэр: Албан тушаал: Гарын үсэг:	
Саналын хуудсыг хүлээлгэн өгсөн огноо, цаг:	
Саналын хуудсыг хүлээн авсан этгээдийн нэр, гарын үсэг:	


Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм Үгүй

Комиссын дарга: /...../

Гишүүд: /...../

..... /...../

Саналын хуудсыг хүчингүйд тооцох үндэслэл:




2025 оны 04 дугаар сарын 25-ний өдрийн
25/04 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт

“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

“Монгол шуудан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 10:00 цагт “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн хурлын танхимд болно.
/Төв шуудангийн баруун хаалга, “Монгол шуудан” ХК-ийн 4 давхарт/

№	Үйл ажиллагаа	Шийдвэр	Хугацаа	Хариуцах эзэн
1	Бүртгэлийн үйл ажиллагаа - Хурлын ирцийг бүртгэх, мэдээлэх	Тогтоол	09:30-10:00	Тооллогын комисс
2	Хурлын нээлт - Хурлыг нээх, хурлын дэг танилцуулах		10:00-10:10	Хурлын дарга
3	Хэлэлцэх асуудал-1: Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах; - Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах, - Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн Аудитын хорооны дүгнэлтийг танилцуулах, - Компанийн 2023 оны ногдол ашиг тараасан тухай тайлан, 2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах, - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны тайлан, дүгнэлтийг танилцуулах, Асуулт, хариулт	ХЭХ-Тогтоол	10:10-11:30	Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн Аудитын хорооны дарга Д.Балдорж Хараат бус гишүүн Б.Золбоо ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл
4	Хэлэлцэх асуудал-2: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсөв батлах; - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг танилцуулах, Асуулт, хариулт		11:30-11:40	Цалин урамшууллын хорооны гишүүн Б.Ганбаатар
5	Хэлэлцэх асуудал-3: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох тухай; - “Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэшигчдийг танилцуулах, Асуулт, хариулт		11:40-11:50	Нэр дэвшүүлэх түр хорооны гишүүн Д.Балжинням
6	Санал хураалтыг нэгтгэх /Завсарлага/		11:50-12:20	Тооллогын комисс
7	Санал хураалтын дүн болон хурлаас гарах шийдвэрийг танилцуулах	Тогтоол	12:20-12:25	Тооллогын комисс Хурлын дарга
8	Хурал хаах		12:25-12:30	Хурлын дарга

Хурал урьдчилсан байдлаар 2 цаг 30 мин үргэлжилнэ.



2025 оны 03 дугаар сарын 13-ний өдрийн
25/04 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБОГДСОН
МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ, БЭЛЭН БОЛГОХ ХУГАЦАА

№	Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох мэдээлэл	Бэлэн болгох хугацаа
1	<p>"Монгол шуудан" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал</p> <ul style="list-style-type: none">- Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан- Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт- Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт- 2023 оны ногдол ашиг тараалтын тайлан болон 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хураарилах тухай ТУЗ-ийн тогтоол- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны тайлан- Бусад хэлэлцэх асуудалтай холбоотой материалууд- ХЭ-чдийн ээлжит хурлаас гарах шийдвэрийн төслүүд	2025.03.23